

**2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаан хаданд  
байрлах “Гаалийн хяналтын талбай” төсөл

“ФҮЖИБИТ” ХХК

АГУУЛГА

ОРШИЛ .....	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
1.1. Төслийн нэр .....	4
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага .....	4
1.3. Төслийн байршил .....	4
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи .....	5
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	9
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл .....	9
2.2. Газрын гадарга.....	9
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг .....	10
2.4. Гадаргын болон гүний ус.....	11
2.5. Хөрсөн бүрхэвч .....	12
2.6. Ургамлан нөмрөг.....	14
2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил .....	15
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	16
3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд.....	16
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	18
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	27
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	29
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
АРВАН ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	33
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ .....	34

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил .....	4
Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн бүдүүвч .....	5
Зураг 3. Гаалийн хяналтын талбай .....	6
Зураг 4. Авто машины зогсоол .....	6
Зураг 5. Харуулын байр .....	7
Зураг 6. Гаалийн хяналтын талбайн салхины хаалт .....	7
Зураг 7. Авто пүү /SCS 200T/, дугуйт ачигч /SEM 656D/ .....	7
Зураг 8. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал .....	8
Зураг 9. Төсөл хэрэгжих орчны агаарын дундаж температур .....	9
Зураг 10. Төслийн талбай орчмын геоморфологи .....	10
Зураг 11. Төслийн талбай орчмын геологийн тогтоц .....	11
Зураг 12. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт .....	12
Зураг 13. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч .....	13
Зураг 14. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг .....	15
Зураг 15. Гадаа байрлуулах хогийн савны жишээ .....	28
Зураг 16. Мониторингийн цэгүүдийн байршил .....	29

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд .....	5
Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл .....	16
Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл .....	16
Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл .....	16
Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл .....	17
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
Хүснэгт 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	24
Хүснэгт 9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	25
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	27
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил .....	29
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	30
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ .....	32
Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	33
Хүснэгт 15. БОМТ-ний нийт зардал .....	34

## **ОРШИЛ**

“Фүжибит” ХХК нь 2017 оны 4 дүгээр сарын 20-нд үүсгэн байгуулагдсан. Манай компани нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг Цагаан хад хэмээх газар байрлан үйл ажиллагаа явуулж байна.

“Фүжибит” ХХК нь Ханбогд Сумын Засаг даргын 2020 оны 08 сарын 07-ны өдрийн А/225 тоот шийдвэрээр олгосон газар эзэмшүүлэх зөвшөөрлийн дагуу тус талбайд уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг автомашинд ачих буулгах гаалийн хяналтын бүсийн зориулалтаар үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 оны 09-р сарын 08-ны өдрийн А/160 тоот тушаалаар ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС-ээр зарлуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Тус талбай нь авто зам, автомашины зогсоол, уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний овоолгын талбай, хадгалах хэсэг, операторын байр, оффисын байр, хамгаалалтын байр, гэрэлтүүлэг зэрэг гаалийн хяналтын талбайн бүх шаардлагыг хангасан гаалийн хяналтын бүс юм.

“Фүжибит” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багийн нутаг Гашуун сухайт хилийн боомтод түшиглэн байгуулагдсан Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS 5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх нүүрсийг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулна. Гаалийн хяналтын бүсдээ хилийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайнууд болон Эрдэнэс Таван толгой компаний олборлосон экспортын зориулалттай нүүрсийг уурхай дээрээс нь уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийлгэн ачуулж ханги хилийн боомтруу явуулах үйл ажиллагаа эрхэлж байна.

Хоногт 80-100 автомашин буюу 11200-14000 тонн түүхий эд хүлээн авч буулгах, мөн хэмжээний ачааг ачиж гаалийн хяналт хийлгэнэ. Жилд 315 хоног ажиллаж 3,5 сая тонн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн экспортонд гаргана.

Манай компани нь Гашуун сухайт дахь Гаалийн байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр Гаалийн хяналтын бүсэд ажиллах зөвшөөрөл авч шалган нэвтрүүлэх боомт болон хилийн хяналтын бусад албадын ажлын байр. Барилга байгууламж, тээвэр зуучийн болон холбогдох бусад аж ахуйн нэгж, байгууллагын бараа тээврийн хэрэгсэл хадгалах, ачих, буулгах, бараа ялган ангилах талбайг Гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон журмын дагуу тохижуулан ажиллаж байна.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2023 онд “Эм И Си Эс Зэт Би” ХХК боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар баталгаажуулсан.

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

“Гаалийн хяналтын талбай” төсөл

### 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Фүжибит” ХХК

Улсын бүртгэлийн дугаар 000212415


Регистрийн дугаар 617724

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Баянмонгол, 412-122 тоот.

Утас: 88090406

### 1.3. Төслийн байршил

Гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт, Хайрхан багийн нутагт хилээс хойш 20 км-т оршино. Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд Цагаан хаданд 13.6 га талбайг хамран байрлаж байна. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харууллаа.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Гаалийн хяналтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд**

№	X	Y	Талбайн хэмжээ
1	707784.99	4717748.61	13.6 га
2	707682.24	4717921.97	
3	707787.23	4717991.68	
4	708201.03	4718267.33	
5	708325.79	4718070.34	

**1.4. Төслийн хүчин чадал, техник технологи**

**1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга**

“Фүжибит” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багийн нутаг Гашуун сухайт хилийн боомтод түшиглэн байгуулагдсан Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх нүүрсийг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулан ажиллж байна. Гаалийн хяналтын бүсдээ хилийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайнууд болон Эрдэнэс Таван толгой компаний олборлосон экспортын зориулалттай нүүрсийг уурхай дээрээс нь уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийлгэн ачуулж Ханги хилийн боомт руу явуулах үйл ажиллагаа эрхэлж байна.

Хоногт 80-100 автомашин буюу 11200-14000 тонн түүхий эд хүлээн авч буулгах, мөн хэмжээний ачааг ачиж гаалийн хяналт хийлгэнэ. Жилд 315 хоног ажиллаж 3,5 сая тонн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн экспортонд гаргах хүчин чадалтай.



**Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн бүдүүвч**

Гаалийн хяналтын талбай нь авто пүү, пүүний байр, оффис, харуулын байр, нүүрс ачилт буулгалтын хэсэг, чингэлэг ачилт буулгалтын хэсэг, камер, гэрэлтүүлэг зэргээс бүрдэнэ.

2024 онд 350 мянган тн нүүрс экспортлохоор төлөвлөн ажиллаж байна.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 3. Гаалийн хяналтын талбай

Энэхүү гаалийн хяналтын талбай нь нийтдээ 13.6 га талбайтай бөгөөд задгай нүүрс буулгах талбайн хэмжээ 200 м х 600 м бөгөөд 1 удаад хүлээн авах нүүрсний хэмжээ 6000 тн, чингэлэг буулгах талбайн хэмжээ 200м х 200м, 1 удаад 168 чингэлэг хүлээн авах хүчин чадалтай.



Зураг 4. Авто машины зогсоол

“Фүжибит” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан баг, Цагаан хаданд байрлах гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааг “Талын цэнхэг трейд” ХХК-тай байгуулсан FJBT20221011 тоот менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу явуулж байна.

- “Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын талбайн зохион байгуулалтыг хариуцах, шаардлагатай мэргэжлийн ажилтнуудыг хөлслөн ажиллуулах,
- Талбайн тоног төхөөрөмж болон бусад эд зүйлс, эд хөрөнгийг зөв зохистой ашиглах
- Талбайн үйл ажиллагаа, менежментийг хариуцан ажиллана.



Зураг 5. Харуулын байр



Зураг 6. Гаалийн хяналтын талбайн салхины хаалт


Гаалийн хяналтын талбайд ашиглах техник тоног төхөөрөмжийн хувьд 4 ширхэг дугуйт ачигч, 200 тн-ын даацтай авто пүү 1 ширхэгийг байрлуулан үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 7. Авто пүү /SCS 200T/, дугуйт ачигч /SEM 656D/

“Талын цэнхэг трейд” ХХК нь ашиглаж буй эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ арчилгааг хугацаанд нь хийлгэнэ.





Зураг 8. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал

#### 1.4.2. Төслийн дэд бүтцийн шийдлийн мэдээлэл

**Цахилгаан хангамж.** Гаалийн хяналтын талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг төвийн эрчим хүчний системээс хангадаг.

**Дулаан хангамж.** Дулаан хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо Ханбогд сумын цаг уурын үзүүлэлт, оффисын барилгын овор хэмжээ, дулаан хэрэглэгчид болон тэдгээрийн үндсэн зориулалт тавигдах шаардлагын дагуу халаалтыг цахилгаан тень ашиглан хангаж байна.

**Ус хэрэглээний эх үүсвэр.** Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаа явуулахдаа зөөврийн ус авч ашиглана. Талбайгаас 3 км байрлах худгаас гар нүүр угаах ахуйн хэрэглээний усаа авдаг, харин ундны усыг Ханбогдын нэгдсэн цэвэр усны савалгаатай усыг ашигладаг.

**Зам:** Гаалийн хяналтын талбай нь Гашуунсухайт хилийн боомт хүртэл 19 км зайд оршино. Мөн Гашуунсухайт-Цогтцэций чиглэлийн авто замаас 120 м зайд байрлаж байна.

## ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Гаалийн талбай байгуулахаар төлөвлөж буй талбай нь Монгол орны хамгийг дулаан бүсэд багтдаг бөгөөд уур амьсгалын мужлалаар хэт халуун хуурай зунтай, хүйтэн, хуурай өвөлтэй мужд багтана. Цаг агаарын хэмжилтийн дүнгээс үзэхэд зуны улиралын агаарын дундаж температур  $+20^{\circ}\text{C}$  байх бол өвлийн улиралын дундаж температур  $-17^{\circ}\text{C}$  орчим бол жилийн дундаж температурын хэмжээ  $+3^{\circ}\text{C}$  орчимд хэлбэлзэнэ.

Жилд дундажаар 90-100мм орчим хур тунадас унах бөгөөд нийт хур тунадасын 80% зөвхөн дулааны улиралд 4-р сараас 10-р сарын хугацаанд ногдоно. Хур тунадасны ихэнхи хувь нь дулааны улиралд унах учир өвлийн улиралд цастай өдрийн 1-3 орчим байх бөгөөд тогтвортой цасан бүрхүүл тогтдоггүй байна. улиралын хөлдөлт гэсэлтийн гүн хөрсний механик бүрэлдэхүүн болон чийгийн агууламжтай уялдаатайгаар 30 см хүртэл гүнд хэлбэлзэнэ. Салхитай өдрийн тоо жилд 30-40 орчим байх бөгөөд үүнээс шороон шуургатай өдрийн 40 дээш орчим буюу нийт жилийн турш маш их хүчтэй салхины нөлөөнд оршдог байна.




Зураг 9. Төсөл хэрэгжих орчны агаарын дундаж температур

Уур амьсгалын нөхцлийн хуурай- чийг багатай, хүчтэй салхины нөлөөнд оршдог шинж нь төслийн талбайн хөрсөн бүрхэвчийг хуурай, элсэн фракц давамгайлсан, органик бодисын нөөц багатай, давсны агууламж өндөр, карбонатын агууламж их зэргээр илэрдэг.

### 2.2. Газрын гадарга

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах гаалийн хяналтын талбай нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт, Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн бүсэд байрлана. Тус бүс нутагт нь өндөр уул нурууд байхгүй, уулс хоорондын болон тэгш тал, хөндий хоолой зонхилон тархдаг онцлогтой байна. Газрын хотгор, гүдгэрийн үндсэн хэв шинжид элэгдлийн суурьт давхаргат тал, ухаа гүвээт, нугачаат тэгш тал, голын болон нуурын хурдаст талын хэв шинж голчлон илэрнэ.




**Зураг 10. Төслийн талбай орчмын геоморфологи**

Геоморфологийн тогтоц нь цав толгодорхогдуу талын шинжтэй, бага хэрчигдэлтэй жижиг толгод уулаар эмжиж хүрээлэгдсэн ба эдгээр нь Ханбогд Уул (далайн түвшнээс дээш 1350.3м), Жавхлант Уул (1295.2м), Булан Сухай (937.3м), Загалын Хүрэн Овоо (1202.3м) тэмдэгт өндөртэй өндөрлөгүүд байх ба баруун урагшлах тусам өндөржилт нь намсаж, хамгийн нам цэг Дайчингийн Заг (878.5м) болно. Нутаг дэвсгэр ихэвчлэн нам дор талархаг боловч ОюуТолгойн зүүн өмнөд хэсгээс Умдайн голыг Жавхлант багийн төвийн орчмоор хөндлөн гарах хүртэл 14км дагуу хадан гарш бүхий жижиг толгод, нугачаа, БНХАУ-тай хиллэх хилийн орчим нутгаар далайн түвшнээс дээш 1150-1196м тэмдэгт өндөртэй жижиг аараг толгодтой.

### 2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Төсөл хэрэгжиж буй талбай орчмын хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролювийн элс, элсэнцэр хурдасаас тогтоно. Ийм гаралтай пролювийн хурдас нь Монголын дорнод хэсгийн элэгдэл-хуримтлалын гаралтай ухаа гүвээт тал болон тэгшивтэр талуудад түгээмэл тохиолдоно. Эдгээр хурдас нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонатын агууламж өндөртэй, хөрсний үе давхаргуудад элсэн фракцийн агууламж өндөр, нам дор газруудад хүнд шавранцар бүтэцтэй байдаг.



Зураг 11. Төслийн талбай орчмын геологийн тогтоц


Энэ төрлийн үндсэн чулуулаг дах шугаман структур бүхий рельеф нь судалж буй талбайн зүүн урд хэсгээр буюу Агуйт уул (К-48-60) 1277м, Жавхлант уул (К-48-46) 1295м үнэмлэхүй өндөртэй, харьцангуй өндөр нь 20- 40м хүрнэ. Энэ рельеф нь бага талбайд тархсан шугаман структур бүхий рифей, девон, карбоны тунамал-тиериген хурдас, интрузив чулуулагтай холбоотой. Уг гадаргуугийн гол онцлог нь нэг чиглэлд тасралтгүй сунаж тогтсон, хоорондоо 10-15м өргөнтэй хөндий маягийн хотгоруудаар зааглагдсан зэрэгцээ олон гүвээнүүдээс тогтоно.

#### 2.4. Гадаргын болон газрын доорх ус

Гаалийн талбайн орчимд гадаргын усны хэлбэр байхгүй. Ус зүйн сүлжээгээр Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба Гидрогеологийн мужлалтаар улирлын хомс тэжээлтэй районд багтдаг.

Өмнийн Говийн бүс нутагт хүчтэй аадар борооны дараах гадаргуун усны урсацаас бусад тохиолдолд гадаргуун ус хязгаарлагдмал бөгөөд алслагдсан булаг шанд бага байдаг. 2 м-ийн гүнд орших бага гүний ус бүхий давхаргууд малчдын болон тэдгээрийн малаа услах гол эх үүсвэр болдог бөгөөд хангалттай гүехэн түвшинд байх тохиолдолд томоохон зэрлэг амьтдын ундаалах ус болдог. Энэхүү бага гүний ус нь гүний усны тогтмол давхаргатай хамааралтай байх хайлаас зэрэг ургамлуудыг тэтгэж байдаг.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 12. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт

Судалгаанд хамрагдаж буй талбай нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах бөгөөд Монгол орны Галба-өөш-долоодын усны сав газарт багтана. Тус сав газрын ихэнх хэсэгт тогтмол урсацтай гол мөрөн байхгүй, гадаргын усны ажиглалт хэмжилтийн сүлжээ, судалгаа шинжилгээний материал харьцангуй хомс харин багахан хэмжээний түр зуурын урсацтай горхи, булаг, шнд байх бөгөөд гол мөрний урсац маш бага бүс нутагт хамаарагдана. Гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь гидрогеологийн мужлалын хувьд улирлын хомс тэжээлтэй мужын дорноговийн дэд мужид хамрагдана. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ (1979-2010 оны дундаж) нь Ханбогд суманд 94.1 мм ба хур тунадасны хамгийн их утга (27.1 мм) 8-р сард ажиглагддаг бол хамгийн бага утга нь (0,9 мм) 12-р сард тус ажиглагддаг байна. Хур тунадас нь ихэвчлэн богино хугацаанд аадар хэлбэрээр унах бөгөөд нийт хур тунадасны 90 орчим хувь нь 7-8 саруудад орно. Хүчтэй аадрын дараа хуурай сайруудаар үерийн ус буух нь ажиглагддаг. Хүчтэй аадар бороо нь өргөн талбайг хамарч орох нь ховор, ихэвчлэн бага талбайг хамарч янз бүрийн хэмжээгээр унадаг байна.


### 2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрс- газарзүйн мужлалтын хувьд говийн хөрс -био уур амьсгалын их мужийн өргөрөгийн бүсшилийн хэв шинж бүхий цөлийн бор саарал хөрсний 14-р Галбын говийн тойргийн нутагт багтана. Тус тойрогт говийн цөлөрхөг хээрийн бор хөрс (*Хээржүү цөлийн цайвар бор, говийн бор хөрс*) голчлон тархах бөгөөд нам өндөртэй цав толгодуудаар сайр чулуурхаг говийн бор хөрс, түүнтэй бэл болон ам хөндий газраар цайвар бор хөрс, бусад нам дор хотос газруудаар сул элсэн болон эсэн хучаастай хөрс зонхилон тархсан шинжтэй. Гаалийн талбайн дийлэнхи хэсэгт элсэн хучаас бүхий говийн бор хөрс тохиолдоно. Төслийн талбайд тархсан элсэн болон говийн бор хөрс нь сийрэг ургамал бүрхэвчтэй, үндэсний тархалтын гүн 30

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

орчим, хөрсний үе давхаргад чулуугүй, гүндээ давсжилтын нөлөөгөөр нягтшил нэмэгдсэн, хөрсний гадаргад элсний хучаас үүссэн зэрэг шинжүүд илэрч байна.

Төслийн талбайд тархсан зонхилох хэв шинжийн товч тодорхойлолтыг Акад Д.Доржготов (2003) “Монгол орны хөрс” бүтээлээс хэсэгчилэн оруулав. Монгол орны хуурай гандуу бүс нутагт зонхилон тархах, говийн бүсийн заримдаг цөлийн цавйар бор болон элсэн хучаастай, сийрэг элсэн хөрсний зонхилох хэв шинжүүд нь эх газрын хуурай, халуун уур амьсгалтай нөхцөлд тогтворждог, хөрсний өнгөн хэсэг, дээд үеүүд нь хүчтэй халж, ургамлын үлдэгдлийн эрдэсжих үйл явц эрчимтэй явагддаг тул органик бодисын хуримтлал нь өөрчилөгдөж ялзмагт хуримтлалын давхарга нь илэрч харагдахгүй, бордуу өнгөтэй хатуувтар өнгөн үе мэдрэгддэг.



Зураг 13. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

Хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд гаалийн талбайд тархсан цөлийн бор саарал хөрсний хими шинж чанарын хувьд урвалын орчин дээд үе давхаргад 7.7 байгаа бол доод үед 8.5 шүлтлэг шинжтэй байна. Карбонатын агууламж хуурай уур амьсгалын нөлөөгөөр хөрсний дээд үед 3.29, доод үе давхаргад 4.94% хэмжээтэй байна. Карбонат болон урвайн орчинтой холбоотойгоор хялбар уусах давсны агууламж өнгөн хэсэгт 0.71% байгаа бол доод үе давхаргуудад 0.32% тус хэмжээтэй байна. Хуурай гандуу цөлийн бүсэд тогтворжих цөлийн бор саарал хөрс нь хэт халуун уур амьсгалын нөхцөлд эрдэсжилт болон шавар үүсэх үйл явц хурдацтай явагддаг онцлогтой. Ялзмагт үе илрэхгүй бөгөөд хөрсний үржил шимийн үзүүлэлт болон ялзмагийн хэмжээ дээд үе давхаргад 2.73%, доод үе давхаргад 1.63% ядуулаг агууламжтай байгаа бол хөдөлгөөнт суурь ( $P_2O_5 + K_2O$ )-ийн нийлбэр дээд үед 18.1 мг/100гр хүрэх бол доод үед 11.5 мг/гр тус хэмжээтэй байна.

Ширхэгийн бүрэлдэхүүний хувьд говийн бүсийн хөрсний дээд үед салхин хуримтлалын нөлөөгөөр том ширхэгтэй элсэн фракцын хэмжээ давамгайлах бол доод үед шавар үүсэх үйл явцтай холбоотойгоор нарийн ширхэгт шавранцар фракцийн агууламж давамгайлдаг шинжтэй.

Гаалийн талбайн хөрсний өнгөн хэсэгт 3см хүртэл зузаантай элсэн үе үүссэн байгаа бол түүнээс доошхи үе давхаргуудад цулдам бүтэцтэй шаварлэг эрдсээс тогтсон шинжтэй байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг лабораторид Качинскийн аргаар тодорхойлсон бөгөөд элс:шавар:тоос-ны харьцаа 60:25:15 харьцаатай байна.

Цөлийн бор саарал хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнд элс (2.0-0.05мм) –н хэсгийн агууламж 62.7-67%, тоос (0.05-0.002мм)-н хэсгийн агууламж 20.3-27%, нарийн ширхэгт шавар (< 0.002мм)-н агууламж 17% тус хэмжээтэй байгаа бөгөөд нарийн ширхэгт шаврын агууламж 17% орчим буюу хөрсний ангилалаар хөнгөн шавранцар бүтэцтэй байна. Судалгааны талбайн хөрсний хүнд элементийн бохирдлыг тодорхойлохдоо хээрийн судалгааны ажлын хүрээнд төслийн талбайн ялгаатай газар ашиглалтын хэлбэрүүд, эвдрэлийн төлөв байдалтай уялдуулан, өнгөн хөрсний хүнд элементийн агууламжийг тодорхойлох дээж таблайгаас цуглуулсан. Гаалийн талбайн өнгөн хөрсний дээжинд өргөн тархалттай хүнд элементүүд болох (Pb, Cd, Zn, Cd, Ni, Cr) элементүүдийн агууламжийн магадлан итгэмжлэгдсэн “Грийн лаб” ХХК-ийн лабораторид ICP-MS багаж ашиглан тодорхойлуулсан.


Гаалын хяналтын талбайн хүнд элементийн бохирдлын MNS5850:2019 харьцуулан тодорхойлсон. Судалгааны үр дүнгээс харахад гаалийн хяналтын талбайн хөрсний хүнд элементийн агууламжийн хувьд Cd-ийн агууламж илрээгүй буюу багажны мэдрэгч чанарт бүртгэгдээгүй байгаа бол Pb агууламж 1.1мг/кг маш бага агууламжтай гарсан байгаа бол (Cr, Pb, Cd, Zn, Cu, Ni) хүнд элементүүдийн хувьд Cr: 11-12.8мг/кг, Pd: 1.0-3.2мг/кг, Zn: 35.7-97.1 мг/кг, Cu: 19.6-36.5мг/кг, Ni:20.5-52.5 мг/кг тус агууламжтай байна. Гаалийн талбайн хөрсний хүнд элементийн агууламж нь Монгол улсын стандарт MNS5850:2019 –д заасан хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдолтой утга илрээгүй байна.

Хөрсний нянгийн бохирдлын түвшинг үнэлэхэд нийт нянгийн тоо болон савханцрууд (E.Coli), агааргүй орчинд үрждэг (Cl. perfringens) анаэроб бактери гэсэн гурван үзүүлэлтүүдийг нянгийн бохирдлын ерөнхий үнэлгээний үзүүлэлт болгон ашигласан. Судалгааны ажлын зорилгын дагуу гаалийн талбайд 1 цэгээс нянгийн бохирдлын дээж авсан. Шинжилгээний дүнгээс харахад *Salmonella* бактери аль ч цэгт илрээгүй буюу бохирдолгүй, харин нийт нянгийн тоо MNS6341 стандартад заасан  $1 \times 10^5$  утгаас хэтрээгүй буюу бохирдолгүй байна. *E.coli* савханцар талбай орчимд 0.1101 буюу бохирдол илрээгүй шинжтэй. Агааргүй орчинд үрждэг *Cl. Perfringens* бактери –ийн агууламж <0.1 буюу бохирдол үүсээгүй байна

## 2.6. Ургамлан нөмрөг

Ургамал газарзүйн мужлалтаар тухайн бүс нутаг нь Сахар-Говь цөлийн их мужийн Төв Азийн мужийн Өлгий хийд- Галбын говийн бүсийн бутлаг үетэнт ба заримдаг сөөгөнцөр, бутлаг үетэнт цөлжүү хээрт хамрагдах ба тэнд ихэвчлэн хазаар өвс-хялганат, хялганат, агь-хазаар өвс хялганат, харгана бүхий агь-хазаар өвс-хялганат, чулуусаг алаг өвс-агь-үетэнт ургамлын бүлгэмдэл зонхилно. Төсөл хэрэгжих талбайд салхиар зөөгдөж хуримтлагдсан элсэн товцог, довон үүссэн бөгөөд үерийн усны хуримтлалын шал, тойром, хотос элбэгтэй. Элсэн товцог бүхий газруудаар цагаан шаваг, цагаан суль, харганы холимог сөөг бүхий бэлчээр илрэхээс гадна харган, заг бүхий өтгөн шугуй тархана.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 14. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг

### 2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь 1924 онд Хаданхошууны Хар овооны бууц гэдэг газар “Галба” нэртэйгээр анх байгуулагджээ. Галба сум 1941 оноос нэрээ сольж Ханбогд хайрханыхаа нэрээр нэрлэгдэн, 80 гаруй жилийн түүхэн замналыг туулж ирсэн түүхтэй. Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай, баруун, хойд талаараа өөрийн аймгийн Манлай, Цогтцэций, Баян-овоо сумдтай, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залган оршдог ба хээр тал, говь цөл хосолсон, Ундайн говь, Байшин цав, Чингисийн уурганы нүх, Хөдөлдөг цохио, Мэлхий хад, Гурван зээрдийн агуй, 3000 хайлааст, Сэвхүүлийн элс, Хаалгын рашаан, алдарт Галбын говь зэрэг байгалийн үзэсгэлэнт газар бүхий 1515.2километр квадрат нутаг дэвсгэртэй.

Төсөл хэрэгжих Өмнөговь аймгийн Ханбогд сум нь хээр тал, говь цөл хосолсон 1515.2 кв.км нутаг дэвсгэртэй. Аймгийн төвөөс 260 км, нийслэл Улаанбаатар хотоос 760 км зайтай ба өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг. Тус сум нь засаг захиргааны 5 багтай ба 2021 оны мэдээгээр 8404 хүн ам, 2116 өрхтэй



### ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд

##### 3.1.1. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх нь:

“Фүжибит” ХХК-ийн машин техникийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт, шатах тослох материалын ууршилт, машин механизмын яндангаар хаягдах хорт хий, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр агаарын хими, физикийн бохирдолтод орох зэргээр давхардмал бохирдолтуудад орох магадлалтай.

##### Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн үр дагавар				
		Маш бага	Бага	Дунд	Их	Онц аюултай
1	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүр дэх шаталтын процессос үүсэх хорт хий		+			
2	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжүүд			+		
3	Тээвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт				+	

##### 3.1.2. Төслөөс хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нь:

Хөрс нь хүний болон машин техникийн нөлөөгөөр тагтаршиж доройтсон байна. Нүүрс ачилт буулгалтын талбайн барилга байгууламжийн үед болон нүүрсийг ачих буулгах тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны нөлөөнд тухайн газрын гадарга бага зэрэг өртөж доройтсон байна.

##### Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн үр дагавар				
		Маш бага	Бага	Дунд	Их	Онц аюултай
1	Нүүрсний хадгалалт			+		
2	Нүүрсний тээвэрлэлт			+		

Бохирдол, эвдрэлийн эх үүсвэр нь:

- Тээврийн хэрэгслээс шатах тослох материал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах
- Нүүрс тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед тоос, тортог салхины нөлөөгөөр тархах, хөрсөн бүрхэвчийг доройтуулах, үржил шимийг бууруулах
- Машин механизмын тоо олширсноор хөрсөн бүрхэвч доройтох, эвдрэх

##### 3.1.4. Төслөөс гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх нь:

Төслийн үйл ажиллагаанд ямар нэгэн ус ашиглагдахгүй харин ажилчдын усан хангамжинд багахан хэмжээний ус хэрэглэгдэнэ.

##### Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн үр дагавар
---	-------------------	-----------------------

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		Маш бага	Бага	Дунд	Их	Онц аюултай
1	Ахуйн бохир ус, хатуу хог хаягдал ил задгай хаягдаж алдагдсанаас гадаргын болон газрын доорх ус бохирдох			+		

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр:

- Ахуйн хэрэглээний усыг их хэмжээгээр авч ашигласанаас үүдэн газрын доорх усны нөөц хомсдох, түвшин буурах
- Шатах тослох материалын асгаралт хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, улмаар хур борооны урсацаар дамжин гадаргын усыг бохирдуулах

**3.1.5. Төслөөс ургамлан нөмрөгт нөлөөлөх нь:**

Машин техник, хүний хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

**Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл**

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн үр дагавар				
		Маш бага	Бага	Дунд	Их	Онц аюултай
1	Ургамлан нөмрөгийн талхагдал			+		
2	Ургамлын төрөл зүйлийн хомсдох		+			

**3.1.6. Амьтны аймагт нөлөөлөх нь:**

Төсөл хэрэгжүүлэх Цагаан хад болон нүүрс тээвэрлэх замаас говь хээрийн туурайтан амьтан аль хэдийн зугтаж дайжсан, жижиг амьтад ч гэсэн өөрийн популяцаар үржих болсон тул ижил төстэй бусад компаниас илүү нөлөөлөх онцлог байхгүй болно. Уг талбайн ойр орчимд нь иргэдийн төвлөрөл үүсэж ойр орчимд байх зэрлэг ан амьтан дайжсан болно. Уг талбай нь өөрийн эзэмшил хашаатай учир нохой муур, таван хошуу мал зэрлэг ан амьтан нэвтрэх боломжгүй юм.

**3.1.7. Түүх, соёлын дурсгалт зүйлст нөлөөлөх нь:**

Түүх, соёлын зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг Монгол Улсын хуулиар зохицуулдаг бөгөөд энэ талаар ноцтой зөрчил одоогийн байдлаар гараагүй байна. Төсөл хэрэгжүүлэх 13.6 га талбайд түүх, соёлын дурсгалт зүйл байхгүй болно.

**3.1.8. Нийгэм, эдийн засагт нөлөөлөх нь:**

Төсөл хэрэгжиснээр ажлын байр тодорхой хэмжээгээр нэмэгдэх давуу талтай. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална. Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жил бүр мөрдөн ажилладаг байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах болно.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төслийн үйл ажиллагааны ажлын үе шатанд байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзний хамтаар төлөвлөн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад чиглэнэ.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган 2024 онд хэрэгжүүлэх байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

**Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<i>Агаар орчин</i>								
1	Машин механизмаас ялгарах хорт утаа нь агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Гаалийн хяналтын талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах		MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга		
2	Агаарт тоосжилт тархах	Нүүрс тээврийн машиныг тээвэрлэлтийн явцад машины тэвшийг хучих, нүүрс унахаас сэргийлэх	Тээвэрлэлтийн зам дагуу	Үйл ажиллагааны зардалд тусгах		MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS ISO 3929:2014 Автотээврийн хэрэгсэл.		
3	Талбайд нүүрс ачиж, буулгаж, хадгалах үед агаарт нүүрсний тоосжилт үүсэх	Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайг тойруулан 8-12 м өндөртэй салхинаас хамгаалах торон хашааг байгуулах, эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд тухай бүрт нь завсарлах	Гаалийн хяналтын талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах				
<i>Хөрсөн бүрхэвч</i>								
6	Хүн, машины хөдөлгөөний улмаас орчмын хөрс	Хог хаягдлын цэгийг зориулалтын сав талбайг зохих шаардлагын дагуу	Төслийн талбай дотор зүүн урд буланд харуулын	850000	3	2250.0	2024 онд	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
7	элэгдэлд орох магадлалтай.	салхины ноёлох чиглэлийн доор байрлуулах	байрны баруун талд					нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх, засвар үйлчилгээг тогтмол хийх	Гаалийн хяналтын талбай	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд			
8	Тоосжилтыг багасгах	Тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах талбайн орц гарцны хэсгийг хайрган хучилттай болгох, дагтаршуулах	Гаалийн хяналтын талбайн орц гарцны хэсгийн 28,263 м <sup>2</sup> талбай				2024 онд	
<b>Ургамлан нөмрөг</b>								
9	Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтох	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлэх, даган мөрдөх	Төслийн талбай	“Фүжибит” ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд орно			2024 онд өдөр бүр	“Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008
10	Ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөх	Олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх	Төслийн талбайд	Ногоон байгууламж байгуулах зардалд тусгах			2024 онд	
<b>Усан орчин</b>								

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
11	Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэх	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Унд, ахуйн хэрэглээний усанд хангамж	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан			2024 онд улиралд 1 удаа	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
12	Ажилчдын хэрэглээнд гүний ус ашигласнаар усны нөөцөд нөлөөлөх	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааны мэдээллийн хуудсыг гаалийн хяналтын зарын самбар, мэдээллийн самбарт байрлуулж шинэчилж байх	Усны эх үүсвэр	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 онд	Усны тухай хууль
13	Хөрсөн бүрхэвч болон усан орчин бохирдохоос сэргийлэх	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байгуулах	Төслийн талбайд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар			2024 онд	MNS 6561 : 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
<i>Амьтны аймаг</i>								
14	Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас	Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах, битүүмжлэлийг	Төслийн талбайд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан			2024 онд	МУ-ын хууль, Амьтны тухай хууль, БО-ны багц хуулиуд

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>№</b>	<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл</b>	<b>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар, хэмжээ</b>	<b>Нэгжийн өртөг /төг/</b>	<b>Тоо, хэмжээ</b>	<b>Нийт зардал /төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа, давтамж</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
	мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй	байнга хянаж шалгаж байх						

**ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд гаалийн хяналтын талбайд ажил гүйцэтгэж буй ажилчдын хотхоны эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

**Хүснэгт 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
<i>Ургамлан бүрхэвч, орчны тохижилт</i>							
1	Нүүрс тээвэрлэлт, ачилт буулгалтын улмаас ургамлан нөмрөг устан, орчны ургамлан бүрхэвч доройтох	Ногоон байгууламж бий болгох, тордож байх	Ханбогд сумын тогтоосон бүсэд, орон нутгийн заасан цэгт		Мэргэжлийн байгууллагын гэрээний үнийн дүнгээр дотоод зардлаар тооцож үйл ажиллагааны зардалд тусгах	“Фүжибит” ХХК, менежмент хариуцсан байгууллага	Орон нутагтай хамтран ажиллах
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих		1,000 ширхэг	11,250	11,250,000	“Фүжибит” ХХК, менежмент хариуцсан байгууллага	ӨМА, БОАЖГ, Байгаль хамгаалах сангийн дансанд төвлөрүүлэх
3	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын хэвлий бохирдох	Цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Гаалийн хяналтын талбайн талбайн гадна, дотор талбайд		Үйл ажиллагааны хүрээнд	Менежмент хариуцсан байгууллага	Бүх нийтийн цэвэрлэгээ хийх болон талбайн цэвэрлэгээ хариуцсан ажилтантай байх



**ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг Цагаан хаданд байрлах Гаалийн хяналтын талбай болон түүний орчимд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд хэрвээ тус төслийн үйл ажиллагааны явцад архелогий, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай Ханыогд сумын, засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах болно.

**Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал, олдвор	Төслийн барилга байгууламжийн ажлын үед соёлын биет өв илэрвэл төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, Энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад мэдэгдэх.	“Фүжибит” ХХК-ийн гаалийн хяналтын талбай	2024 онд соёлын биет өв илэрсэн тохиолдолд	Соёлын өвийн тухай хуулийн 38.3
2	Палеонтологийн дурсгал, олдвор				

**НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь машин техник, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйл ажиллагааны хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

**Хүснэгт 9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга Хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Байгалийн гаралтай осол эрсдэл</b>						
1	Байгалийн гамшгийн улмаас ажилчдын эрүүл мэнд, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарч болзошгүй	Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай бороо орох үед үйл ажиллагааг түр зогсоох	Төсөл хэрэгжих бүс	Үйл ажиллагааны зардал	2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
2		Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт зохион байгуулах	Гаалийн хяналтын талбай		2024 он	
<b>Нийгмийн гаралтай осол эрсдэл</b>						
3	Болзошгүй осол, саагал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, бүртгэл хөтлөх	Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник	Үйл ажиллагааны зардал	Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
4	Төслийн талбайд цахилгаан үүсгүүр болон тамхины цог зэргээс гал түймэр гарч болзошгүй.	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах болон галын хорыг байнга шалгах, цэнэглүүлэх	Төсөл хэрэгжих бүс	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид	
5	Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох,	Ажилчдыг ажилд гарахын өмнө аюулгүй	Төслийн талбай	-	Үйл ажиллагааны	Хөдөлмөрийн аюулгүй

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН  
ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	амь нас эрсдэх, барилгын үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	ажиллагааны зааварчилгаанд хамруулах			туршид	байдлын тухай хууль
6		Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг байршуулах	Гаалийн хяналтын талбай	Үйл ажиллагааны зардал		
7		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан болон дараагийн шатны тусламж үзүүлэх, байнгын эмч ажиллуулах	Төслийн үйл ажиллагааны менежмент хариуцаж буй байгууллага	Эмчийн цалингийн зардлаар	Үйл ажиллагааны туршид	

**ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллана.

**Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Ахуйн хог хаягдал</b>						
1	Энгийн хагуу хог хаягдлыг гэрээний дагуу зайлуулах	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	Гэрээнд заасан үнийн дүнгээр нэхэмэлхийн дагуу төлөх /Менежмент хариуцаж буй байууллагаас/			Хог хаягдлын тухай хууль
2	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав гадна талбайд байрлуулах		3,500,000	1 ш	3500,000	
3	Гаалийн хяналтын талбайн оффис, пүүний байранд 3 ангилдаг хогийн сав байрлуулах		15,000	6 ш	90,000	
4	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж бий болгох		22,000,000	1	22,000,000	
5	Ахуйн бохир ус соруулах гэрээ байгуулах, гэрээний дагуу зайлуулж байх		Гэрээнд заасан үнийн дүнгээр нэхэмэлжлэхийн дагуу төлөх /Менежмент хариуцаж буй байууллагаас/			Хог хаягдлын тухай хууль
<b>Аюултай хог хаягдал</b>						
6	Машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн талбайд болон менежментийн байгууллагын тусгай талбайд	Гүйцэтгэлээр		Хог хаягдлын тухай хууль	
7	Техникийн ашигласан тос, тосолгооны шингэний хаягдлыг хүлээллэгэн өгөх гэрээ байгуулах	Менежмент хариуцаж буй байгууллага				



Зураг 15. Гадаа байрлуулах хогийн савны жишээ

**АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**


Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан мониторингийн цэгүүдэд үндэслэн 2024 оны мониторинг хийх цэг, үзүүлэлтүүдийг дарааН байдлаар сонгон авав.

**Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил**

Цэгийн дугаар	Төрөл	Солбицол*	
		X	Y
1	Агаар	107° 32' 07.7"	42° 35' 09.1"
2	Хөрс 1	107° 31' 57.9"	42° 35' 07.0"
3	Хөрс 2	107° 32' 13.7"	42° 35' 16.4"

Тайлбар: \*-Солбицолын тогтолцоо WGS84 UTM Zone48

Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн нутаг, Цагаан хаданд байрлах Гаалийн хяналтын талбайн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгийн байршлыг дараах зургаар харууллаа.



**Зураг 16. Мониторингийн цэгүүдийн байршил**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
<i>Агаарын бохирдлыг хянах</i>							
Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл	Гаалийн хяналтын талбайд	Жилд 2 удаа	Түгээмэл тархалттай бохирдуулагчид	54,500	109,000	MNS4585: 2016	20 минутын дундаж: Нийт тоос-150 мкг/м <sup>3</sup> PM2.5-50 мкг/м <sup>3</sup> PM10-100 мкг/м <sup>3</sup> SO <sub>2</sub> -50 мкг/м <sup>3</sup> NO <sub>2</sub> -50 мкг/м <sup>3</sup>
<i>Усны бохирдлыг хянах</i>							
Усны ерөнхий үзүүлэлт: рН, температур, өнгө, хатуулаг, биологийн болон химийн хэрэгцээт хүчил төрөгч, гадаргуугийн идэвхит бодис, ууссан хүчилтөрөгч, Анионууд, Катионууд, нянгийн бохирдол	Гал тогоо	Улиралд 1 удаа /жилд 4 удаа/	Усны ерөнхий үзүүлэлт, нян	55,000	330,000	MNS 0900: 2018 MNS 6148: 2008	рН-6.5 – 8.5 NH <sub>4</sub> - 3.0 мгN/л NO <sub>2</sub> – 1 мг/л NO <sub>3</sub> - 50 мг/л PO <sub>4</sub> – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO <sub>4</sub> -500 мг/л Mn-0.1 мг/л
	Ус хангамжийн эх үүсвэр худаг			100,000	200,000		
	Ахуйн бохир усны худаг	Жилд 2 удаа	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	58,000	116,000		
<i>Хөрсний бохирдлыг хянах</i>							
Ерөнхий: Чийг, хуурай үлдэгдэл, рН, ялзмаг, Хүнд металл: (Cu, Zn, Cd, Pb, As, Sn) Нянгийн бохирдол	Гаалийн хяналтын талбайн 2 цэгээс	Жилд 2 удаа	Ерөнхий, агрохимийн үзүүлэлтүүд	68,500	137,000	MNS 5850:2019 MNS ISO 11074-1:2001 MNS ISO 11074-2:2001 MNS 5546 :	Pb-100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu-100 мг/кг Zn-300 мг/кг
				100,000	200,000		

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
		Жилд 2 удаа	хүнд металл, нянгийн бохирдол	100,000	200,000	2005	Сп-25 Илрэхгүй
<b>Хэмжилт дээжлэлт гүйцэтгэх инженерийн томилолт</b>		Жилд 2 удаа	УЦУОШГ-н инженер	50,000	100,000	-	-
<b>Орчны хяналт шинжилгээний нэг жилийн зардлын дүн, төгрөг:</b>							<b>1,392,000</b>



**АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. 2024 онд байгаль орчныг хамгаалах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

<b>№</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Хариуцсан албан тушаалтан</b>
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, мөрдөж ажиллах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх, орон нутагтай хамтран ажиллах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлэх	“Фүжибит” ХХК-ийн удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
4	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага, ХАБЭА-н алба
5	Байгаль орчныг хамгаалах талаар холбогдох сум, орон нутгийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
6	Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага, ХАБЭА-н алба
7	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах	“Фүжибит” ХХК-ийн удирдлага

**АРВАН ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Гаалийн хяналтын талбай” төсөл нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОАЖЯ-д тайланг цахимаар хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

**Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх  
хуваарь**

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах, тайлагнах хэлбэр	Зардал, мян.төг
1	Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	2024 оны 11-р сарын 1-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, дүгнэлт гаргуулах	Цахим хэлбэрээр, хэвлэмэл хэлбэрээр	100,0
2	Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин аялал жуулчлалын яам/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	2024 оны 11-р сарын 1-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, дүгнэлт гаргуулах	Цахим хэлбэрээр Байгаль орчны мэдээллийн санд оруулах	100,0

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ  
ЗАРДАЛ**



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 оны нийт зардал 38,432,000 (гучин найман сая дөрвөн зуун гучин хоёр мянган) төгрөг болно.

**Хүснэгт 15. БОМТ-ний нийт зардал**

<b>№</b>	<b>Зардлын хэлбэр</b>	<b>Зардал, төгрөг</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны зардлаар
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11,250,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны зардлаар
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	25,590,000
6	Орчны хяналт шинжилгээний зардал	1,392,000
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	200,000
	<b>Нийт</b>	<b>38,432,000</b>

# ХАВСРАЛТ

- Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Гаалийн хяналтын бүс тогтоох тухай Гаалийн ерөнхий газрын тушаал
- Газрын кадастрын зураг
- Газар эзэмших эрхийн гэрчилгээ
- Газар эзэмшүүлэх гэрээ
- Төслийн талбайн ачиж буулгах талбайн орд гарцны хэсгийн фото зураг

		
<b>МОНГОЛ УЛС</b> <b>ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН</b> <b>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</b> 000298102		
2017.04.20	9011861255	
<i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	<i>/ Хувийн хэргийн дугаар /</i>	
	6175724	
	<i>/ Регистрийн дугаар /</i>	
Фүжибит	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
<i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
<b>Дүрэм</b> <i>/ Үүсгэн байгуулах баримт бичиг /</i>		
Шийдвэр	01	2017.04.18
<i>/ шийдвэрийн нэр /</i>	<i>/ дугаар /</i>	<i>/ он, сар, өдөр /</i>
7210	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх	
49230	Авто машинаар ачаа тээвэрлэх	
45400	Авто машины засвар, үйлчилгээ	
45300	Авто машины сэлбэг, эд ангийн худалдаа	
45209	Авто машины дугуй засвар	
45100	Авто машины худалдаа	
46100	Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	
52290	Агуулах-ч болон тээврийн туслах үйл ажиллагаа	
<i>/ Код /</i>	<i>/ Үйл ажиллагааны чиглэл /</i>	
Хугацаагүй	2	340,500.00
<i>/ хугацаа /</i>	<i>/ гишүүдийн тоо /</i>	<i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Өмнөговь, Ханбогд, 4-р баг, Баян, Шар дов, 17-2 тоот, Утас1: 88101808, Утас2: , Факс: <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
	<b>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b> <b>ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС</b> <i>/ Бүртгэсэн байгууллагын нэр /</i> УЛСЫН БҮРТГЭГЧ Ш.ОЧИРСҮРЭН <i>/ тэмдэг /</i> <i>/ дарын үсэг /</i>	
Гэрчилгээ дахин олгосон 2024 он 02 сар 19 өдөр		

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Wang овогтой Chang Qing-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2024.02.19	Ш.Очирсүрэн
2	Дахин гэрчилгээ олгов.	2024.02.19	Ш.Очирсүрэн



000298102

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

“Фүжибит” ХХК-ийн гаалийн  
хяналтын бүс тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.1, 271<sup>1</sup>.1.9, 271<sup>1</sup>.1.17 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам” –ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 04/06 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Фүжибит” ХХК -ийн Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан, 5 дугаар баг, Цагаан хад суурьшлын бүсэд байрлах, 4601009717 нэгж талбарын дугаартай 13.6га талбайг уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн ачих, буулгах, экспортлох зориулалт бүхий гаалийн хяналтын бүсээр 3 жилийн хугацаагаар тогтоосугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ын 4 дүгээр хавсралтад “Фүжибит - 314061” гэж нэмсүгэй.
3. “Фүжибит” ХХК-тай гэрээ байгуулан, Гаалийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Гашуунсухайт дахь гаалийн газар /Л.Ганбаяр/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, шалгалтын газар /Б.Даваасүрэн/-т, Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА




Б.АСРАЛТ

. 1439501 2358

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ НЬ ГАЗАРТ БЭХЭЛСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар:  
Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн овог, нэр: "ФҮЖИБИТ" ХХК  
Хаяг: Өмнөговь аймаг, Ханбогд сум, 5-р баг Хайрхан, Цагаан хад

Регистрийн дугаар: 6175724



Солбицлын систем: WGS84 UTM-48n

Дугаар	X	Y	Өндөр	Урт	Цэгүүд
1	4717748.612	707784.991	1009.355	201.52	1-2
2	4717921.973	707682.242	1007.565	126.02	2-3
3	4717991.682	707787.226	1006.698	497.21	3-4
4	4718267.327	708201.030	1005.348	233.17	4-5
5	4718070.337	708325.789	1003.858	629.26	5-1

Талбайн хэмжээ: 136000.0 квадрат метр

Хэмжилт үйлдсэн:  
Огноо: 2020-08-10  
Байгууллагын нэр: "Гурван Хорол" ХХК  
Хэмжигчийн нэр: /Б.Ууганхүү/  
Хянасан:  
Огноо: 2020-08-10  
Байгууллагын нэр: "Гурван Хорол" ХХК  
Хэмжигчийн нэр: /Б.Отгонтуул/

Зургийн масштаб 1:5 000 (1 сантиметрт 50 метр багтана)  
Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбицолжуулсан үндэслэлийн цэг:  
Цэгийн солбицол 1: X=4717593.539 Y=714107.976 H=1116.300 Триангуляци  
Цэгийн солбицол 2: X= Y= H=



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН  
ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН  
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000009882

Фүжибит ХХК

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

6175724

(регистрийн дугаар)

/-д

Ханбогд сумын Засаг даргын

(шийдвэр гаргагч)

-ын 20 20

оны 08

сарын 07

өдрийн А/225

тоот

шийдвэрийг үндэслэн

Өмнөговь

(аймаг, шийшлэл)

Ханбогд

(сум, дүүрэг)

Хайрхан-5

(баг, хороо)

Цагаан хид

(гудамжны нэр)

(хашааны дугаар/ тоот)

хаягт

байрлах, нэгж талбарын

4601009717

дугаар бүхий

13.6 га

м.кв /га/ газрыг

Гаалийг хяналтын талбай

зориулалтаар

15

жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн

Э-1112000150

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.



ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН  
БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН

ТАМГА / ТЭМДЭГ



(гарын үсэг)

М.Оюун-Эрдэнэ

(нэр)

20 20 оны 10 сарын 01 өдөр

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тамга
1			

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



Нэгж талбарын дугаар: 4601009717  
Улсын бүртгэлийн дугаар: Э-1112000150  
Гэрчилгээний дугаар: 000009882

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР  
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 10 сарын 2 өдөр

№ 04631-2020/00060

Өмнөговь аймаг Ханбогд сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Өмнөговь аймаг Ханбогд сумын Засаг даргын 2020 оны 07 сарын 10 -ны өдрийн A/225 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Өмнөговь аймаг Ханбогд сум Газрын албаны мэргэжилтэн Мөнх-Очир овогтой Оюун-Эрдэнэ газар эзэмшигчийг төлөөлж Фүжибит ХХК-ны овогтой нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ 136000 м2  
Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт	Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ	Газар эзэмших хугацаа
Гаалийн хяналтын талбай	9.5	3 жил
Ногоон байгууламж	4.1	

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар эзэмшигчийн эрх

- 3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;
- 3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;
- 3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;
- 3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;
- 3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.
- 3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах/;
- 3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь

хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

#### Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ 5 жилд нэг удаа хийлгэнэ./;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
- 4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
- 4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
- 4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
- 4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
- 4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх
- 4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах
- 4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
- 4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
- 4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
- 4.19. Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх
- 4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

#### Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

- 5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
- 5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
  - а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх
  - б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх
  - в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах
  - г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй; эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр\* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй\* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

#### Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

#### Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар эзэмшүүлэгч;  
Өмнөговь аймгийн Ханбогд сум  
Засаг даргын Тамгын газар 105 дугаар өрөө

Газар эзэмшигч: **Фүжибит ХХК** овогтой  
Газрын байршил: **Өмнөговь Ханбогд 5-р баг Цагаан хад**  
Газар эзэмшигчийн хаяг: **Улаанбаатар Хан-Уул 15-р хороо**  
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: /6175724/

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:

Ханбогд сумын Засаг дарга  
Ш.Эрдэнэжаргал /...../тамга

Сумын Газрын даамал  
М.Оюун-Эрдэнэ  
гарын үсэг /...../

Газар эзэмшигчийг төлөөлж:

**Фүжибит ХХК-ны Захирал ажилтай**  
**Нямдорж овогтой Отгонболд**

/гарын үсэг/...../тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг 4601009717 дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн талбайн ачиж буулгах талбайн орц гарцны хэсэг /2024.04.15/

